



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 6/01

Баян-Өндөр сум

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.2.2, 57.2.4 дэх заалт, Улсын Их Хурлын "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2007 оны 73 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3, 12 дугаар хавсралт, Засгийн газрын "Журам батлах тухай" 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нарын цалинг хавсралтаар баталсугай.
2. Шинэчлэн тогтоосон цалинг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ

My.doc.2025 on Zasag dargiin zahiramj



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар Б/01

Баян-Өндөр сум

Цалин шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.5, 2.10," Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 12 дугаар сарын 25-ний өдрийн 238 дугаар тогтоолын 3,10, 11, 12 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" 12 дугаар сарын 28- ны өдрийн 491 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын Улс төрийн албан тушаалын онцгой нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2007 оны 73 дугаар тогтоол, Засгийн газрын "Журам батлах тухай" 2018 оны 382 дугаар тогтоолын 2.4.5 дугаар хавсралт болон 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 2.1, 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын ажилчдын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацаа, орон нутгийн нэмэгдэл, зэрэг дэв, мэргэжлийн зэрэг, ур чадвар, онцгой нөхцлийн нэмэгдэл бусад нэмэгдлийг хавсралтаар баталсугай.

2. Шинэчлэн тогтоосон цалинг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР